

06



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 152

Номгон

“Баян-Агро” орон нутгийн өмчит аж ахуйн  
тооцоотой үйлдвэрийн газар байгуулж,  
дүрмийг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “ж”, 20 дугаар зүйлийн 20.1, 25 дугаар зүйлийн 25.1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн эдийн засгийг сэргээн хөгжүүлж, тогтвортой хөгжлийг бий болгох зорилгоор баталсан “Баялаг бүтээгч-Баянхонгор” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Баян-Агро” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар (ОНӨААТҮГ)-ыг байгуулж, дүрмийг хавсралтаар баталсугай.

2. “Баян-Агро” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар (ОНӨААТҮГ)-ыг Улсын бүртгэлд бүртгүүлж, бүтэц, орон тоог баталж, удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг аймгийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Норов)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Э.ЭНХБАТ

0121328



**"БАЯН-АГРО" ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН  
ТООЦООТОЙ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ДҮРЭМ**

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1 Энэхүү дүрэм нь орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын эрх зүйн байдал, үйл ажиллагааны чиглэл, удирдлагын бүтэц, тэдгээрийн чиг үүргийг тодорхойлсон эрх зүйн үндсэн баримт бичиг мөн.

1.2 "Баян-Агро" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар (ОНӨААТҮГ) нь өөрийн үйл ажиллагааны орлогоор санхүүжих замаар бие даан үйл ажиллагаа явуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд орон нутгийн төсвийн санхүүжилт, хөрөнгө оруулалтаар үйл ажиллагаа эрхлэн явуулах орон нутгийн өмчит үйлдвэрийн газар мөн.

1.3 "Баян-Агро" ОНӨААТҮГ (цаашид "Баян-Агро" гэх) нь Баянхонгор аймгийн Засаг даргын харъяанд байж Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Монгол Улсын бусад холбогдох хууль тогтоомж, аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, аймаг, сумын Засаг даргын захирамж, аймгийн үйл ажиллагааны хөгжлийн хөтөлбөр, нийгэм эдийн засгийн зорилт болон энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.

1.4 Энэхүү дүрмийн зорилго нь "Баян-Агро" ОНӨААТҮГ-ын эрхлэх үйл ажиллагааны чиглэл, бүтэц, удирдлага зохион байгуулалт, хяналт, үйлдвэрийн газрын өмчлөл, түүнийг өөрчлөн байгуулах зэрэгтэй холбогдсон харилцааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохицуулах бөгөөд дүрмийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батална.

1.5 Газрыг албан ёсоор "Баян-Агро" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар ("Баян-Агро" ОНӨААТҮГ) гэж нэрлэнэ.

1.6 Газар нь бие даасан тайлан тэнцэлтэй өөрийн нэрийн өмнөөс эрх эдэлж, үүрэг хүлээдэг, өөрийн эд хөрөнгөтэй ашгийн төлөө, бие даасан хуулийн этгээд юм.

1.7 "Баян-Агро" ОНӨААТҮГ нь өөрийн оноосон нэр, албан бичгийн хэвлэмэл хуудас, тамга, тэмдэг, санхүүгийн харилцах данс хэрэглэнэ.

1.8 Энэхүү дүрмийг "Баян-Агро" ОНӨААТҮГ-ын Удирдах зөвлөл, удирдлага, албан тушаалтан, ажилтан заавал дагаж мөрдөнө.



1.9 Дүрмийн хэрэгжилтэд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, ОНӨААТҮГ-ын Төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.

#### ХОЁР. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

2.1 "Баян-Агро" ОНӨААТҮГ нь хууль тогтоомж, орон нутгаас баримталж буй бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд урт болон богино хугацааны бизнес төлөвлөгөөгөөр эрхэм зорилго зорилтоо тодорхойлох, аймагт хөдөө аж ахуйг хөгжүүлэх кластер төслийг хэрэгжүүлэхэд тэргүүлэх үүрэг гүйцэтгэж, тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх болон мал аж ахуйн үйлдвэрлэлд цөм сүргийг бий болгох, үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүнийг эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагааг явуулна.

2.1. "Баян-Агро" ОНӨААТҮГ-ын эрхлэх үйл ажиллагааны үндсэн чиглэл нь:

- 2.1.1. Малын тэжээлийн ургамал тариалах;
- 2.1.2. Хүнсний ногоо тариалах;
- 2.1.3. Хүлэмжийн ногоо тариалах;
- 2.1.4. Байгаль экологийн тэнцвэрт байдлыг хадгалахад зориулж мод үржүүлэх, тарих;
- 2.1.5. Мах сүүний чиглэлийн үхрийн аж ахуй хөгжүүлэх;
- 2.1.6. Мах, ногооны зоорийн аж ахуй эрхлэх;
- 2.1.7. Малын цөм сүргийг өсгөх, үүлдэр, угсааг сайжруулах;
- 2.1.8. Газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрт хэрэгжүүлэх MNS, ISO, GMP стандартуудаас тохируулан сонгож нэвтрүүлэх;
- 2.1.9. Хэрэглэгчдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн үйлдвэрлэн гаргаж буй бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, хөгжүүлэх ажлыг тогтмол хийх;
- 2.1.10 Үйлдвэрээс гарч буй нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг дотоод, гадаадын зах зээлд борлуулах;
- 2.1.11 Дээр дурдсанаас бусад хуулиар хориглоогүй бизнесийн үйл ажиллагаа явуулж орлогоо нэмэгдүүлэх;

#### ГУРАВ. "БАЯН-АГРО" ОНӨААТҮГ-ЫН ЭД ХӨРӨНГИЙН ЭРХ

3.1 "Баян-Агро" ОНӨААТҮГ нь өөрийн эзэмшиж байгаа эд хөрөнгийн хэмжээгээр эрх эдэлж, хариуцлага хүлээнэ.

3.1.1 "Баян-Агро" ОНӨААТҮГ нь эд хөрөнгийн талаар дараах эрх, үүрэгтэй байна.

3.1.2 Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын шаардлага хангахгүй болсон хөрөнгийг акталж данснаас хасах, худалдан борлуулах, устгах, шилжүүлэх, шинээр олж авах талаар эрх бүхий байгууллагад санал уламжлах эрхтэй;

3.1.3 Өөрт олгогдсон үл хөдлөх хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмшиж, ашиглана;

3.1.4 Үйлдвэрийн үйл ажиллагааны үр дүнд олсон ашгаас эрх бүхий байгууллагаас баталсан нормативт хэмжээгээр өөртөө үлдээж захиран зарцуулах;

3.1.5 Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ өөрөө бие даан борлуулах.

3.1.6 Улсын болон орон нутгийн төсөл, өөрийн олсон орлогоор хийгдсэн хамаарал бүхий бүтээн байгуулалтын ажлын явцад хяналт тавьж, үйлдвэрийн газрын өмчид шилжигдэх үед хөрөнгийн чанарт үнэлгээ хийж хүлээн авна.

#### ДӨРӨВ. БҮТЭЦ, УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

4.1 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь аймгийн Засаг дарга, төсөл санаачлагчид санал болгосноор "Баян-Агро" ОНӨААТҮГ-ыг үүсгэн байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг шийдвэрлэнэ.

4.2 Баян-Агро ОНӨААТҮГ-ийн Удирдах зөвлөлийн гишүүдийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар томилно.

4.3 "Баян-Агро" ОНӨААТҮГ-ын бүтэц орон тооны дээд хязгаарыг ТЭЗҮ, бизнес планд үндэслэн аймгийн Засаг дарга тогтооно.

4.4 "Баян-Агро" ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх удирдлагыг удирдах зөвлөлийн саналаар аймгийн Засаг дарга томилно.

4.5 Гүйцэтгэх удирдлага нь захирал байх бөгөөд захирал нь аймгийн Засаг даргатай Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн хөдөлмөрийн гэрээ байгуулж байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр батлуулан хэрэгжилтийг хагас бүтэн жилээр тайлагнана. Мөн Орон нутгийн өмчийн газартай "Өмч эзэмшлийн гэрээ"-г жил бүр байгуулж дүгнүүлнэ.

#### ТАВ. ЗАХИРЛЫН ЭРХ, ҮҮРЭГ

5.1. Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд, газрын дүрэм, зорилтын санал, бизнес төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжүүлэх, үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг шуурхай удирдлагаар хангах ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хариуцна.

5.2. Аймаг, сумын Засаг дарга, Орон нутгийн өмчийн газар, харилцагч байгууллага, ажил олгогчтой байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, удирдаж буй газрын хэвийн үйл ажиллагааг хангасны үндсэн дээр санхүү, төлбөрийн чадвар, нэр хүндийг бүх талаар дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулна.

5.3. "Баян-Агро" ОНӨААТҮГ-ын эрх ашгийг дээдэлж, мэргэжил, ажлын дадлага, туршлагаа бүрэн дайчлан ажиллаж аливаа асуудалд ажил хэрэгч идэвхи санаачлагатай үнэнч шударгаар хандан байгууллагын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг биелүүлэх, ажил үйлчилгээний чанарыг дээшлүүлж, ажилчдынхаа нийгмийн асуудлыг оновчтой шийдвэрлэж ажиллана.

5.4. Ажил үүргээ гүйцэтгэх явцад олж авсан үйл ажиллагааны болон бизнесийн нууцыг чанд хадгалах, хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх



5.5. Баталсан удирдлагын бүтэц, зохион байгуулалтын хүрээнд ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, цалингийн хэмжээ, урамшууллын журмыг тогтоох, хууль тогтоомжийн хүрээнд ажлаас чөлөөлнө,

5.6. Захирал нь хууль тогтоомжид нийцүүлэн хөдөлмөрийн дотоод журам боловсруулан баталж мөрдөх ба хувийн эрх ашгийн үүднээс байгууллагын нэрийг ашиглан гэрээ хэлцэл хийхгүй байна.

5.7. "Баян-Агро" ОНӨААТҮГ-ын захирал нь эрх бүхий байгууллагаас олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, үйлдвэрийн газрыг төлөөлөх зэргээр үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулна.

5.8. "Баян-Агро" ОНӨААТҮГ-ын захирал нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргана.

5.9. Үйлдвэрийн газрын үндсэн, туслах үйлдвэрлэл үйлчилгээний ажлыг хэвийн явуулах зорилгоор мэргэжил, ур чадвар сайтай дадлага туршлагатай гадны ажилчдыг гэрээгээр авч ажиллуулж, ажлын хөлс урамшуулал олгоно.

5.10. Тухайн үеийн зах зээлийн бүтээгдэхүүний үнийн өсөлт инфляцын түвшинтэй уялдуулан ажил үйлчилгээний үнэ тариф, ажилчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх, өөрчлөх санал, тооцоо гаргаж холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.

5.11. Ажилчдын нийгмийн асуудлыг үе шаттай шийдвэрлэж, идэвх санаачилга үр бүтээл, тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлэн хамт олны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх бүх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

5.12. Албан тушаалын тодорхойлолт болон гэрээгээр хүлээсэн үүргээ цаг хугацаанд нь биелүүлнэ.

5.13. Төсвийн хөрөнгийг төсвийн тухай хуульд заасны дагуу үр ашигтай зарцуулах буюу төсвийн зарцуулалтын эрхийг удирдах зөвлөлөөр шийдвэрлүүлсний дараа зарцуулалтыг гүйцэтгэнэ.

#### ЗУРГАА. УДИРДАХ ЗӨВЛӨЛ

- 6.1. Удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй байна.
- 6.2. Зөвлөлийн даргыг Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн батлана.
- 6.3. Удирдах зөвлөл, үйлдвэрийн газрын захирлын үйл ажиллагаанд хяналт тавьж, захирлыг удирдлагаар хангаж ажиллана.

#### ДОЛОО. "БАЯН-АГРО" ОНӨААТҮГ-ЫН ХЯНАЛТ

7.1. "Баян-Агро" ОНӨААТҮГ-ын ажилтан албан тушаалтнууд байгууллагын дүрэм, хөдөлмөрийн дотоод журамд заасан үүргийг биелүүлж, байгууллагын ашиг сонирхолын төлөө шударгаар ажиллана.

7.2. Холбогдох хууль тогтоомж, журмын дагуу үйлдвэрийн газрын үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлт гаргуулна.

7.3. "Баян-Агро" ОНӨААТҮГ-ын эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалт, ашиглалтад өмч хамгаалах комисс хяналт тавьж ажиллана. Байгууллагын өмч хамгаалах комиссыг захирлын тушаалаар байгуулна.

7.4. Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу тавих хяналт шалгалтыг нягтлан бодогч хариуцан хэрэгжүүлнэ.

7.5. Удирдах зөвлөл нь захирлын үйл ажиллагаа, санхүүд хяналт тавьж хамтран ажиллана.

#### НАЙМ. "БАЯН-АГРО" ОНӨААТҮГ-ЫН САНХҮҮ БҮРТГЭЛ ТАЙЛАН

8.1. "Баян-Агро" ОНӨААТҮГ нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж, Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу жил бүр гаргаж, аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулна.

8.2. "Баян-Агро" ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлангийн үнэн зөвийг захирал, нягтлан бодогч нар хариуцна.

8.3. "Баян-Агро" ОНӨААТҮГ-ын санхүүгийн жил нь тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, мөн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно.

#### ЕС. "БАЯН-АГРО" ОНӨААТҮГ-ЫН САНХҮҮЖИЛТ, САНХҮҮГИЙН ТАЙЛАН

9.1. "Баян-Агро" ОНӨААТҮГ-ын орлого нь дараах санхүүгийн эх үүсвэрээс бүрдэнэ.

9.1.1. Төсвийн тухай хууль тогтоомжид заасны дагуу орон нутгийн төсвөөс олгох санхүүжилт;

9.1.2. Бараа, ажил үйлчилгээ, үйлдвэрлэлээс олсон бүх орлого;

9.1.3. Байгууллагатай хамтарч ажиллах гэрээний дагуу олсон үйлдвэрлэл, үйлчилгээний орлого;

9.1.4. Төсөл хөтөлбөр, иргэн аж ахуйн нэгж байгууллагаас олгож буй хандив, бэлэглэл, буцалтгүй тусламж, бусад орлого;

9.1.5. Хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэр;

9.2. Үйлдвэрийн газрын санхүүгийн тайланд дараах зүйлийг тусгана:

9.2.1. Баланс

9.2.2. Үйл ажиллагааны ур дүнгийн тайлан

9.2.3. Мөнгөн гүйлгээний тайлан

9.2.4. Өмчийн өөрчлөлтийн тайлан

9.2.5. Нэмэлт тайлбар;

9.2.6. Санхүүгийн тайлангийн тодруулга;



9.2.7. Бусад;

#### АРАВ. “БАЯН-АГРО” ОНӨААТҮГ-ЫН БАРИМТ БИЧГИЙГ ХАДГАЛАХ

10.1. “Баян-Агро” ОНӨААТҮГ нь албан хэрэг хөтлөлт, архивын нийтлэг журмыг мөрдөн ажиллах бөгөөд дараах бичиг баримтыг хадгална:

10.2. “Баян-Агро” ОНӨААТҮГ-ын дүрэм, түүнд орсон нэмэлт өөрчлөлттэй холбогдох газруудын шийдвэр, тогтоол, улсын бүртгэлийн гэрчилгээ болон бусад гэрчилгээ сертификатууд;

10.3. Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангууд, түүнд хийгдсэн аудитын дүгнэлт, зөвлөмжүүд;

10.4. Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримтууд, түүнд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох бичиг баримтууд;

10.5. Үйлдвэрлэл, технологи, норм нормативууд түүнтэй холбогдох дүрэм, журам, зааврууд, бусад бичиг баримтууд;

10.6. Хурлын тэмдэглэл, шийдвэр, захирлын тушаал, шийдвэрүүд;

10.7. Тухайн байгууллагын ирсэн, явуулсан албан бичиг

10.8. Тухайн байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуух ач холбогдол бүхий баримт бичгүүд;

10.9. Дээрх бичиг баримтыг зохих журмын дагуу холбогдох этгээдээс хүлээн авч хадгалах, эрх бүхий этгээдэд танилцуулах архивт шилжүүлэх зэрэг ажлыг эрхлэн гүйцэтгэнэ.

#### АРВАН НЭГ. ХАРИУЦЛАГА

11.1. Монгол Улсын хууль, тогтоомж, хөдөлмөрийн гэрээг зөрчсөн бол хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

#### АРВАН ХОЁР. БУСАД

12.1. Энэ дүрэмд тусгагдаагүй бусад асуудлыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

12.1 Дүрэмд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулах бөгөөд тэдгээр нь энэхүү дүрмийн салшгүй хэсэг мөн.

12.2 Дүрэм батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.